



**НИЙСЛЭЛИЙН
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.2 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.7 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2, 23.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын дэргэд оюутны шигшээ баг, дүүргүүдийн Засаг даргын дэргэд өсвөрийн шигшээ багийг шинэчлэн байгуулахад шаардлагатай баримт, бичгүүдийн төслийг боловсруулж, оюутны шигшээ багийн бүтэц, бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга	М.Цогзолмаа	Захиргаа төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга;
Гишүүд	Э.Мөнх-Эрдэнэ	Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн ахлах мэргэжилтэн;
	А.Амарзаяа	Эрх зүй тогтоол, шийдвэр хариуцсан мэргэжилтэн;
	Ө.Мягмаржав	Төрийн болон аж ахуй нэгж, байгууллага дахь биеийн тамирын асуудал хариуцсан мэргэжилтэн;
	Д.Жаргалсайхан	Монголын оюутны спортын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга;
Нарийн бичиг	Г.Бямбасайхан	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. Нийслэлийн Засаг даргын дэргэд оюутны шигшээ баг, дүүргүүдийн Засаг даргын дэргэд өсвөрийн шигшээ багийг шинэчлэн байгуулахад шаардлагатай баримт, бичгүүдийг боловсруулах, Нийслэлийн Засаг даргын дэргэд оюутны шигшээ багийн бүтэц бүрэлдэхүүнийг хууль эрх зүйн хүрээнд сонгон шалгаруулах ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж байгууллагын удирлагад танилцуулахыг ажлын хэсэг (М.Цогзолмаа)-т үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга М.Цогзолмаад даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.САРАНЦЭЦЭГ